

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2011 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

ЭВЛЭРҮҮЛЭН ЗУУЧЛАЛЫН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь эрх зүйн маргааныг шүүхийн бус аргаар эвлэрүүлэн зохицуулах эрх зүйн үндсийг тогтоох, эвлэрүүлэн зуучлах ажиллагааны журам, энэхүү ажиллагаанд оролцогчдийн эрх, үүргийг тодорхойлоход оршино.

2 дугаар зүйл. Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль тогтоомж

2.1.Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль тогтоомж нь Иргэний хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай, Гэр бүлийн тухай, Хөдөлмөрийн тухай, Арбитрын тухай, Шүүхийн тухай, Шүүхийн захиргааны тухай болон энэ хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Иргэний эрх зүйн харилцаанаас үүссэн, тэдгээрийн дотор аж ахуйн болон эдийн засгийн бусад үйл ажиллагаатай холбоотой маргаан, түүнчлэн хөдөлмөрийн болон гэр бүлийн харилцаанаас үүссэн маргаанд эвлэрүүлэн зуучлалыг хэрэглэнэ.

3.2.Энэ хуулийн 3.1.-д зааснаас бусад харилцаанаас үүссэн маргаанд эвлэрүүлэн зуучлалыг зөвхөн хуульд тусгайлан заасан тохиолдолд хэрэглэж болно.

3.3.Эвлэрүүлэн зуучлалыг шүүхэд иргэний хэрэг, арбитраг маргаан үүсгэснээс хойш хянан шийдвэрлэх ажиллагаанд хэрэглэж болно.

3.4.Хөдөлмөрийн хамтын маргаанд, түүнчлэн энэ хуулийн 3.1-д заасан харилцаанаас үүссэн маргаан нь эвлэрүүлэн зуучлалд оролцоогүй гуравдагч этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг, эсхүл нийтийн ашиг сонирхлыг хөндөхөөр бол эвлэрүүлэн зуучлалыг хэрэглэж болохгүй.

3.5.Хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн зохицуулалт иргэний хэргийн зохигчдыг эвлэрүүлэх, эвлэрэхэд нь дэмжлэг үзүүлэх шүүх, шүүгчийн үйл ажиллагаанд хамаарахгүй.

4 дүгээр зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“эвлэрүүлэн зуучлал” гэж талуудын харилцан зөвшөөрөл, сайн дурын үндсэн дээр хоёр талын ашиг сонирхолд нийцэхүйц шийдвэрт хүрэх зорилготой, маргааныг эвлэрүүлэн зуучлагчийн туслалцаатайгаар зохицуулах шүүхийн бус аргыг;

4.1.2.“талууд” гэж эвлэрүүлэн зуучлах журмаар энэ хуулийн 3.1-д заасан маргааныг зохицуулах хүсэлт гаргасан иргэн буюу хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй этгээдийг;

4.1.3.“эвлэрүүлэн зуучлагч” гэж тухайн маргааны талаар талуудаас шийдвэр гаргахад нь туслалцаа үзүүлэх, маргааныг зохицуулахад зуучлахыг нь талууд сонгосон буюу зөвшөөрсөн, мэргэшсэн болон мэргэшлийн бус этгээдийг;

4.1.4.“эвлэрүүлэн зуучлах байгууллага” гэж эвлэрүүлэн зуучлах ажиллагааг зохион байгуулж явуулах үйл ажиллагаа нь тухайн этгээдийн үйл ажиллагааных нь үндсэн чиглэл болох хуулийн этгээдийг;

4.1.5.“эвлэрүүлэн зуучлалыг /шүүхийн бус аргыг/ хэрэглэх талаарх тохиролцоо” гэж эрх зүйн тодорхой харилцаанаас талуудын хооронд үүссэн, эсхүл үүсэж болох маргааныг эвлэрүүлэн зуучлалын журмаар шийдвэрлэхээр маргаан үүсэхээс өмнө буюу маргаан үүссэний дараа талуудын хооронд бичгээр хийсэн хэлцлийг;

4.1.6.“эвлэрүүлэн зуучлах ажиллагааг хэрэгжүүлэх тухай тохиролцоо” гэж маргааныг эвлэрүүлэн зуучлалын журмаар зохицуулах талаар эвлэрүүлэн зуучлагчтай хийсэн талуудын хэлцлийг;

4.1.7.“эвлэрлийн тохиролцоо” гэж маргаан буюу тодорхой санал зөрөлдөөнтэй асуудалд эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулсны үр дүнд талуудын хооронд бичгээр хийсэн хэлцлийг.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ЭВЛЭРҮҮЛЭН ЗУУЧЛАХ АЖИЛЛАГАА

5 дугаар зүйл. Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны зорилго, үндсэн зарчим

5.1.Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны зорилго нь эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд оролцогч талуудын сонирхолд нийцсэн шийдлийг олох, талуудын хоорондох харилцааны зөрчил, маргааныг эвийн журмаар зохицуулахад оршино.

5.2.Эвлэрүүлэн зуучлах ажиллагааг талууд хүсэл зоригоо харилцан зөвшилцөж илэрхийлсэн нөхцөлд сайн дурын, талуудын тэгш эрхийн, зуучлагчийн хараат бус, хөндлөнгийн байдлын, нууцлалын зарчмуудад үндэслэн явуулна.

6 дугаар зүйл.Эвлэрүүлэн зуучлах журмаар маргаан шийдвэрлэх харьяалал

6.1.Талууд маргаанаа эвлэрүүлэн зуучлах журмаар шийдвэрлүүлэхийн тулд хүсэлтээ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 14, 15, 16 дугаар зүйлд заасан харьяаллын дагуу анхан шатны шүүх дэх эвлэрүүлэн зуучлах хэсэгт, эсхүл энэ хуулийн 8 дугаар зүйлд заасан эвлэрүүлэн зуучлах байгууллагад гаргана.

6.2.Шүүх маргалдагч талуудад эвлэрүүлэн зуучлалын талаарх мэдээллийг бүрэн өгч, шүүхэд иргэний хэрэг үүсгэхээс өмнө болон хойно, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны шат бүрд талуудыг эвлэрэх боломжоор хангаж, эвлэрүүлэн зуучлагчийн туслалцаа авах талаар сануулах үүрэгтэй.

6.3.Гэр бүлийн эрх зүйн харилцаанаас үүссэн маргаанд эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явагдаагүй бол эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулах боломжгүйгээс бусад тохиолдолд шүүх иргэний хэрэг үүсгэхгүй.

6.4.Талууд маргааныг эвлэрүүлэн зуучлалын журмаар шийдвэрлүүлэхээр гэрээндээ хэлэлцэн тохиролцсон бол шүүхийн бус аргаар урьдчилан шийдвэрлэх журам тогтоосон гэж үзнэ.

6.5.Энэ хуулийн 6.3, 6.4-т заасан журмыг зөрчиж нэхэмжлэл гаргасан бол шүүх Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 65.1.3-т зааснаар нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзана.

6.6.Эвлэрүүлэн зуучлах ажиллагаа амжилтгүй болсон бол талууд, түүнчлэн талуудын аль нэг тал эвлэрлийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд нөгөө тал тухайн асуудлаар шүүхэд хандах эрхтэй ба эдгээр байдал нь шүүхээс Иргэний хуулийн 79, 80 дугаар зүйлд зааснаар хөөн хэлэлцэх хугацааг сэргээх, эсхүл уг хугацааг тасалдсан гэж үзэх үндэслэл болно.

7 дугаар зүйл.Шүүх дэх эвлэрүүлэн зуучлах хэсэг

7.1.Анхан шатны шүүх дээр эвлэрүүлэн зуучлах хэсэг ажиллана.

7.2. Энэ хуулийн 7.1-д заасан хэсгийн үйл ажиллагааны зохион байгуулалт, хүний нөөцийн удирдлагыг Шүүхийн ерөнхий зөвлөл болон тухайн шүүхийн тамгын газар хариуцаж, холбогдох төсвийг тухайн шүүхийн төсвөөс гаргана.

7.3.Энэ хуулийн 7.1-д заасан хэсэгт дээд боловсролтой, эвлэрүүлэн зуучлагчийн сургалтад хамрагдан эрхийн гэрчилгээ авсан, шүүх дээр эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулах эвлэрүүлэн зуучлагчдын нэрсийн жагсаалтад бүртгэгдсэн мэргэшсэн эвлэрүүлэн зуучлагчийг ажиллуулна.

7.4.Мэргэшсэн эвлэрүүлэн зуучлагч нь энэ хууль болон Мэргэжлийн зөвлөлөөс баталсан ёс зүйн дүрэм болон бусад журмыг баримтлан ажиллана.

8 дугаар зүйл.Төрийн болон төрийн бус байгууллагын дэргэдэх эвлэрүүлэн зуучлах төв

8.1.Төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоод үйл ажиллагааныхаа чиглэлийн дагуу тухайн салбар эрх зүйн харилцаанаас үүссэн маргааныг шийдвэрлэх эвлэрүүлэн зуучлах төвийг ажиллуулж болно.

8.2.Энэ хуулийн 8.1-д заасан төвд дээд боловсролтой, эвлэрүүлэн зуучлагчийн сургалтад хамрагдан эрхийн гэрчилгээ авсан, тухайн чиглэлийн асуудлаар эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулах эвлэрүүлэн зуучлагчдын нэрсийн жагсаалтад бүртгэгдсэн мэргэшсэн эвлэрүүлэн зуучлагчийг ажиллуулна.

8.3.Мэргэшсэн эвлэрүүлэн зуучлагч нь энэ хууль болон Мэргэжлийн зөвлөлөөс баталсан ёс зүйн дүрэм болон бусад журмыг баримтлан ажиллана.

9 дүгээр зүйл.Мэргэшлийн бус эвлэрүүлэн зуучлагч

9.1.Эрх зүйн бүрэн чадамжтай, ял шийтгэлгүй аливаа этгээд эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулах эрхтэй ба мэргэшлийн бус эвлэрүүлэн зуучлагчдын ажиллагааг энэ хуулиар зохицуулахгүй.

10 дугаар зүйл.Мэргэжлийн зөвлөл

10.1.Мэргэшсэн эвлэрүүлэн зуучлагчид эрх ашгаа хамгаалах, эвлэрүүлэн зуучлах ажиллагааны эрх зүйн болон зохион байгуулалтын асуудлыг шийдвэрлэх зорилгоор Мэргэжлийн зөвлөлийг Шүүхийн Ерөнхий зөвлөлийн дэргэд байгуулна.

10.2.Мэргэжлийн зөвлөлийг эвлэрүүлэн зуучлагч, шүүгч, Шүүхийн ерөнхий зөвлөл, судлаач зэрэг 15 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулна.

11 дүгээр зүйл.Мэргэжлийн зөвлөлийн бүрэн эрх

11.1.Мэргэжлийн зөвлөл нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

11.1.1.эвлэрүүлэн зуучлах ажиллагааны дүрэм, журам, эвлэрүүлэн зуучлагчийн зардал, ажлын хөлс, урамшууллын журам, эвлэрүүлэн зуучлагчийн ёс зүйн дүрэм, ажлын байрны стандартыг боловсруулах, батлах, хэрэгжилтэд хяналт тавих;

11.1.2.эвлэрүүлэн зуучлагчийг бэлтгэх, давтан сургах сургалтын хөтөлбөрийг боловсруулах, сургалтыг зохион байгуулах;

11.1.3.эвлэрүүлэн зуучлагчийг сонгон шалгаруулах, эрхийн гэрчилгээ олгох;

11.1.4.эвлэрүүлэн зуучлагчийг бүртгэх, нэрсийн жагсаалтыг олон нийтэд нээлттэй зарлах ажлыг зохион байгуулах;

11.1.5.эвлэрүүлэн зуучлагчийн эрхийг түдгэлзүүлэх, хасах, гэрчилгээг хүчингүй болгох, нэрсийн жагсаалтаас хасах;

11.1.6.Мэргэжлийн зөвлөлийн хуралдааны дэгийг тогтоох.

11.2.Мэргэжлийн зөвлөл нь төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын дэргэдэх эвлэрүүлэн зуучлалын төвүүд болон шүүх дэх эвлэрүүлэн зуучлах хэсгүүдэд ажиллах эвлэрүүлэн зуучлагч нарын нэрсийг холбогдох байгууллагуудад санал болгоно.

11.3.Мэргэжлийн зөвлөлийн санал болгосон эвлэрүүлэн зуучлагч нарын нэрсийн жагсаалтаас энэ хуулийн 8 дугаар зүйлд заасан байгууллага болон Улсын дээд шүүх эвлэрүүлэн зуучлагч нарыг сонгон бүртгэж, тэднийг холбогдох журмын дагуу ажиллах нөхцөл, боломжоор хангаж ажиллана.

ГУРАВДУГААР БҮЛЭГ ЭВЛЭРҮҮЛЭН ЗУУЧЛАХ АЖИЛЛАГААНЫ ОРОЛЦОГЧ

12 дугаар зүйл.Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны оролцогч

12.1.Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны оролцогч нь маргааны талууд болон эвлэрүүлэн зуучлагч байна.

12.2.Эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд хоёр ба түүнээс дээш тал, нэг ба хэд хэдэн зуучлагч оролцож болно.

12.3.Эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд талууд биечлэн, эсхүл төлөөлөгчөөрөө дамжуулан оролцоно.

12.4.Хуульд өөрөөр заагаагүй бол эвлэрүүлэн зуучлах ажиллагааны явцад талууд харилцан зөвшилцсөний үндсэн дээр өмгөөлөгч, орчуулагч, хэлмэрч болон бусад этгээдийн туслалцаа авч болно.

12.5.Энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд гуравдагч этгээд оролцож болно.

13 дугаар зүйл.Эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд оролцогч талуудын эрх, үүрэг

13.1.Эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд оролцогч талууд дараах эрхийг эдэлнэ:

13.1.1.маргаанаа эвлэрүүлэн зуучлах журмаар зохицуулах талаар өөрийн хүсэл зоригийг аливаа дарамт шахалтгүйгээр чөлөөтэй илэрхийлэх,

эвлэрүүлэн зуучлах ажиллагаагаар маргааныг шийдвэрлүүлэхийг зөвшөөрөх, татгалзах;

13.1.2.харилцан зөвшилцөж тохиролцох асуудлын хүрээг чөлөөтэй сонгох, шаардлагаа ихэсгэх, багасгах, маргаанаас татгалзах;

13.1.3.хэрэг хуваарилагдсан эвлэрүүлэн зуучлагчийг зөвшөөрөх, татгалзах, эвлэрүүлэн зуучлагчийг сонгох талаар хүсэлт гаргах;

13.1.4.ажиллагааны арга хэлбэрийг сонгох, энэхүү ажиллагаанд байр сууриа тодорхойлох, хамгаалах, мэдээлэл авах, маргааныг зохицуулах тохиролцооны нөхцөлийг үнэлэх;

13.1.5.эвлэрүүлэн зуучлах ажиллагааны үйл явц, түүний үр дагавар, мөн эвлэрлийн тухай тохиролцоонд гарын үсэг зурснаас үүсэх үр дагаврын талаар мэдээлэл авах;

13.1.6.эвлэрэн хэлэлцсэн тохиролцоог сайн дураар биелүүлээгүйгээс үүсэх үр дагаврын талаар мэдээлэл авах;

13.1.7. эвлэрүүлэн зуучлалын аль ч үед уг ажиллагаанаас татгалзах;

13.1.8.эвлэрэн хэлэлцсэн тохиролцоонд гарын үсэг зурах;

13.1.9.эвлэрлийн тохиролцоог нөгөө тал биелүүлээгүй тохиолдолд хэлцлийг шүүхээр баталгаажуулж, гүйцэтгэх хуудас бичүүлэх, эсхүл шүүхэд нэхэмжлэл гаргах;

13.1.10.эвлэрлийн тохиролцоог буруу хийсэн гэж үзсэн тохиолдолд шүүхэд нэхэмжлэл гаргах;

13.1.11.хуульд заасан бусад эрх.

13.2.Эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд оролцогч талууд дараах үүргийн хүлээнэ:

13.2.1.эвлэрэн хэлэлцсэн тохиролцоонд гарын үсэг зурсан тохиолдолд уг тохиролцоогоор хүлээсэн үүргээ сайн дураар, шударгаар гүйцэтгэх;

13.2.2.энэ хуульд заасан журмын дагуу эвлэрүүлэн зуучлах ажиллагааны хураамж, ажлын хөлс, зайлшгүй зардлыг хариуцах;

13.2.3.эвлэрүүлэн зуучлах журмаар маргааныг шийдвэрлүүлэхээр хүсэлт гаргасан, эсхүл энэ ажиллагаанд оролцохыг зөвшөөрсөн нөхцөлд талууд эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд идэвхи, санаачилгатай оролцох, эвлэрүүлэн зуучлагчийн дуудлага, товлосон уулзалтад хүрэлцэн ирэх;

13.2.4.хуульд заасан бусад үүрэг.

14 дүгээр зүйл.Эвлэрүүлэн зуучлагчийн эрх, үүрэг

14.1.Эвлэрүүлэн зуучлагч дараах эрхийг эдэлнэ:

14.1.1.маргаан бүхий зөрчлийн шинж байдлаас шалтгаалан талуудтай хэлэлцэн тохиролцож тогтсон хураамж, хөлс авах, эвлэрүүлэн зуучлах ажиллагаатай холбоотой гарсан зардлыг нөхөн төлүүлэх;

14.1.2.нууцлалыг хадгалах зарчмыг баримтлан үйл ажиллагааныхаа талаар олон нийтэд мэдээлэх;

14.1.3.энэ хуульд заасан журмыг дагаж мөрдөн эвлэрүүлэн зуучлах үйл явцыг зохион байгуулахдаа өөрийн арга, хэлбэрийг сонгон хэрэглэх, маргааныг шийдвэрлэх талаар талуудад амаар болон бичгээр зөвлөмж өгөх;

14.1.4.эвлэрүүлэн зуучлах ажиллагааг талууд болон төрийн байгууллага, албан тушаалтан, бусад хуулийн этгээд, иргэдээс хараат бус явуулах;

14.1.5.хуульд заасан бусад эрх.

14.2.Эвлэрүүлэн зуучлагч дараах үүрэг хүлээнэ:

14.2.1.хууль тогтоомжид зааснаар эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулах боломжгүй тохиолдолд түүнээс татгалзах;

14.2.2.эвлэрүүлэн зуучлах ажиллагааны зарчмыг чандлан сахиж, үйл ажиллагаагаа талуудын аль алины эрх, ашиг сонирхолд нийцүүлэн тэдний тэгш оролцоог хангаж явуулах;

14.2.3.талуудад эвлэрүүлэн зуучлалын үйл явц, түүний зорилго, үр дагварын талаар мэдээлэл өгөх;

14.2.4.маргаанд ямар нэг хувийн ашиг сонирхолгүйгээр төвийг сахин, эвлэрүүлэн зуучлах үйл явцыг удирдах;

14.2.5.эвлэрүүлэн зуучлагчийн ёс зүйн дүрмийг чандлан сахиж;

14.2.6.эвлэрүүлэн зуучлах ажиллагааны явцад талуудаас итгэмжлэн өгсөн баримт сэлтийг буцааж өгөх;

14.2.7.талуудын аль нэгэнд эрх зүйн болон бусад зөвлөгөө өгөх, туслалцаа үзүүлэхгүй байх;

14.2.8.хуульд заасан бусад үүрэг.

15 дугаар зүйл. Эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд өмгөөлөгч оролцох

15.1.Өмгөөлөгч үйлчлүүлэгчийнхээ хүсэлтээр эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд оролцох тохиолдолд маргааныг эвлүүлэн зуучлалын журмаар

шийдвэрлэх тохиролцооны нөхцөл болон үр дагаврын талаар түүнд тайлбарлах үүрэгтэй.

15.2.Өмгөөлөгч мэргэшсэн эвлэрүүлэн зуучлагч бол өөрийн явуулсан эвлэрүүлэн зуучлах ажиллагааны оролцогч аль нэг талд хожим тухайн асуудлаар хууль зүйн туслалцаа үзүүлэх буюу аль нэг талын өмгөөлөгчөөр оролцох, эсхүл урьд өмнө өмгөөлөгчөөр оролцож байсан хэрэгт эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулахыг хориглоно.

15.3.Өмгөөлөгч талуудын хүсэлтээр эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд оролцох тохиолдолд эвлэрүүлэн зуучлагчийн ажиллагаанд хөндлөнгөөс оролцох, талуудын эвлэрэх явдалд саад учруулахыг хориглоно.

16 дугаар зүйл. Эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд гуравдагч этгээд оролцох

16.1.Эвлэрүүлэн зуучлалын үр дүнд хуулиар хамгаалагдсан ашиг сонирхол нь хөндөгдөхөөр бол гуравдагч этгээдийг өөрийнх нь, мөн зуучлагч болон талуудын хүсэлт, зөвшөөрлөөр уг ажиллагаанд оролцуулж болно.

16.2.Талуудын хүсэлтээр тэдний гэр бүлийн гишүүд, төрөл садангийн хүмүүс болон холбогдох бусад этгээдийг эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд оролцуулж болно.

17 дугаар зүйл.Эвлэрүүлэн зуучлагчийг татгалзан гаргах

17.1.Талууд дангаар, эсхүл харилцан тохиролцсноор эвлэрүүлэн зуучлагчийг татгалзан гаргаж болно. Шүүхэд иргэний хэрэг, арбитраж маргаан үүсгэснээс хойш эвлэрүүлэн зуучлагчийг татгалзан гаргасан бол энэ талаар шүүх, арбитраж мэдэгдэх үүрэгтэй.

17.2.Эвлэрүүлэн зуучлах ажиллагааг зарчмын дагуу хэрэгжүүлэхэд саад болох аливаа нөхцөл байдал бий болсон тохиолдолд эвлэрүүлэн зуучлагч уг ажиллагаанаас нэн даруй татгалзан гарах үүрэгтэй.

17.3.Эвлэрүүлэн зуучлагч өөрийн хүчин зүтгэлээр талуудыг эвлэрэлд хүргэж чадахгүй гэж үзсэн бол эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулахаас татгалзах, эсхүл талуудын санал, зөвшөөрлийн дагуу эвлэрүүлэн зуучлах ажиллагааг дуусгавар болгох эрхтэй.

ТАВДУГААР БҮЛЭГ ЭВЛЭРҮҮЛЭН ЗУУЧЛАХ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

18 дугаар зүйл. Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны нийтлэг үндэслэл

18.1.Эвлэрүүлэн зуучлагч болон эвлэрүүлэн зуучлах байгууллагын ажилтнууд төвийг сахисан, шударга байр суурийг баримтлан ажиллана.

18.2.Талууд эсрэг талдаа мэдэгдэхгүйгээр зуучлагчтай уулзах, тухайн маргаанд өмгөөлөгчөөр ажиллах талаар эвлэрүүлэн зуучлагчид хүсэлт, шаардлага тавих зэрэг хууль бус аливаа үйлдэл, эс үйлдэхгүйгээр эвлэрүүлэн зуучлагчийн төвийг сахисан байр суурийг алдагдахуйц үйлдэл хийхийг хориглоно.

18.3.Эвлэрүүлэн зуучлах байгууллага нь эвлэрүүлэн зуучлагч болон бусад ажилтнуудын ёс зүйн болон ашиг сонирхлын зөрчлийн талаар баримтлах бодлого, чиглэлийг боловсруулж, сургалт зохион байгуулна.

18.4.Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны журам болон эвлэрлийн агуулга нь энэ хууль болон холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна.

18.5.Эвлэрүүлэн зуучлагч болон эвлэрүүлэн зуучлах байгууллагын ажилтнууд өөрийн ажил үүргийн хүрээнд олсон мэдээллийг ажил үүргээ гүйцэтгэж байх үед болон ажлаас чөлөөлөгдсөнөөс хойш задруулж үл болно.

18.6.Эвлэрүүлэн зуучлах байгууллага болон эвлэрүүлэн зуучлагч эвлэрүүлэн зуучлах ажиллагааны явцад олж авсан баримт сэлтийг хууль бусаар ашиглахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна.

18.7.Хуульд зааснаас бусад тохиолдолд үүргээ гүйцэтгэх замаар уг хэргийн байдлыг мэдэх болсон эвлэрүүлэн зуучлагчийг гэрчээр дуудах буюу мэдүүлэг авч болохгүй. Ийнхүү эвлэрүүлэн зуучлах ажиллагааны явцад ил болсон мэдээллийг талуудын зөвшөөрөлгүй бусдад задруулсан этгээд энэ хуульд заасан хариуцлага хүлээнэ.

19 дүгээр зүйл.Эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулах газар

19.1.Эвлэрүүлэн зуучлах ажиллагааг уг ажиллагааны хаалттай явагдах зарчмыг хангах боломжтой зориулалтын танхим, эсхүл талуудын тохиролцсоноор бусад газарт явуулна.

20 дугаар зүйл.Эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулах хугацаа

20.1.Эвлэрүүлэн зуучлах ажиллагааг 30 хоногт багтаан явуулах бөгөөд талуудын хүсэлтээр энэ хугацааг сунгаж болно.

21 дүгээр зүйл.Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны нөхцөл

21.1.Шүүхэд иргэний хэрэг, арбитра маргаан үүсгэсэн эсэхээс үл хамааран талууд хүсэл зоригоороо эвлэрүүлэн зуучлах ажиллагааг хэрэгжүүлэх тохиролцоонд хүрсэн үеэс уг ажиллагаа эхэлнэ.

21.2.Эвлэрүүлэн зуучлах ажиллагаа нь талууд оролцуулахыг зөвшөөрснөөс бусад этгээдийн хувьд хаалттай явагдана.

21.3.Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны үр дүнд хийгдсэн эвлэрлийн тохиролцоо хууль болон гуравдагч этгээдийн эрх ашгийг хөндөөгүй байна.

21.4.Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны явцад талуудыг албадах, шахалт, дарамт үзүүлэх зэрэг аливаа хэлбэрээр нөлөөлөхийг хориглоно.

21.5.Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны оролцогчид уг ажиллагааны явцад олж авсан мэдээллийг мэдээлэл гаргагчийн бичгээр гаргасан зөвшөөрөлгүйгээр бусдад задруулахыг хориглоно.

22 дугаар зүйл.Эвлэрүүлэн зуучлуулах өргөдөл гаргах

22.1.Эвлэрүүлэн зуучлах журмаар маргаанаа шийдвэрлүүлэх хүсэлтэй этгээд эвлэрүүлэн зуучлах байгууллагад өргөдөл гаргана.

22.2.Эвлэрүүлэн зуучлах байгууллага өргөдөл хүлээн авсан тухай болон эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулах товыг талуудад мэдэгдэнэ.

22.3.Талууд эвлэрүүлэн зуучлагчийн нас, хүйс, мэргэшсэн чиглэл, дадлага туршлага зэрэг асуудлаар эвлэрүүлэн зуучлах байгууллагад тусгайлан хүсэлт гаргаж болно.

23 дугаар зүйл.Эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулах хэлбэр

23.1.Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны эхний уулзалтад талуудыг заавал оролцуулна. Энэ уулзалтаар эвлэрүүлэн зуучлагч эвлэрүүлэн зуучлах ажиллагааны дэг, журам, талуудын эрх, үүргийг танилцуулж, талуудын шаардлага, тайлбарыг сонсч, эвлэрүүлэн зуучлах ажиллагааны цаашдын чиглэлийг тодорхойлно.

23.2.Эвлэрүүлэн зуучлах ажиллагааг талуудыг хамтран оролцуулах зарчмын дагуу явуулна. Эвлэрүүлэн зуучлагч нь зөвхөн шаардлагатай тохиолдолд талуудтай ганцаарчилсан уулзалт хийнэ.

23.3.Нэг уулзалтын хугацаа нь талуудын тайлбарыг бүрэн сонсох, харилцан ойлголцоход хангалттай байвал зохино.

24 дүгээр зүйл.Тэмдэглэл

24.1.Эвлэрүүлэн зуучлагч буюу түүний даалгавараар эвлэрүүлэн зуучлах байгууллагын ажилтан ажиллагаа бүрийн тэмдэглэлийг цаг тухайд нь хөтөлнө.

24.2.Тэмдэглэлийг монгол хэл, эсхүл талуудын тохиролцсон хэлээр боловсруулж, түүнд талуудын овог, нэр, ажиллагааны агуулга, хугацаа, дараагийн ажиллагааны хэлбэр, товыг тэмдэглэнэ.

24.3.Эвлэрүүлэн зуучлах байгууллага нь Мэргэжлийн зөвлөлөөс баталсан журмын дагуу эвлэрүүлэн зуучлах ажиллагааны тэмдэглэл болон бусад баримтын хадгалалт хамгаалалтыг хариуцаж, зөвхөн талуудын зөвшөөрөлтэйгээр бусдад үзүүлэх эрхтэй.

25 дугаар зүйл.Эвлэрлийн тохиролцоо

25.1.Талуудын тохиролцооны агуулгыг талууд өөрсдөө, эсхүл тэдний хүсэлтээр эвлэрүүлэн зуучлагч нэгтгэн тусгасан эвлэрлийн гэрээний төслийг боловсруулна.

25.2.Эвлэрлийн гэрээг монгол хэл, эсхүл талуудын тохиролцсон хэлээр боловсруулна. Монгол хэлээс өөр хэлээр боловсруулсан гэрээний албан ёсны орчуулгыг гэрээний салшгүй хэсэг болгон хавсаргана.

25.3.Эвлэрлийн гэрээнд тухайн хэсгийн нэр, огноо, маргалдагч талуудын нэр, хаяг, эвлэрүүлэн зуучлал эхэлсэн огноо, маргааны агуулга, түүний талаарх талуудын байр суурь, тохиролцсон зүйлс болон бусад асуудлыг ойлгомжтой, тодорхой тусгаж, талууд болон зуучлагч гарын үсэг зурж баталгаажуулна.

25.4.Талуудын хүсэлтээр эвлэрлийн гэрээг нотариатаар болон тухайн зуучлах хэсгийн шүүхээр баталгаажуулж болно.

26 дугаар зүйл.Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны хураамж, хөлс

26.1.Эвлэрүүлэн зуучлах байгууллага нь Мэргэжлийн зөвлөлөөс баталсан үлгэрчилсэн дүрмийг үндэслэн эвлэрүүлэн зуучлах ажиллагааны хураамжийн хэмжээ болон эвлэрүүлэн зуучлагчийн хөлсийг тогтооно.

26.2.Шүүх дэх эвлэрүүлэн зуучлах хэсэгт ажиллах эвлэрүүлэн зуучлагчид хөлс олгох журмыг Шүүхийн ерөнхий зөвлөл, санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална. Энэхүү хөлс шүүхийн тэмдэгтийн хураамжийн 50 хувиас ихгүй байна.

26.3.Эвлэрүүлэн зуучлах байгууллага, эвлэрүүлэн зуучлагч нь урьдчилан тохирсон хэмжээнээс илүү хураамж, хөлс авахыг хориглоно.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ ЗАРИМ ТӨРЛИЙН МАРГААНЫГ ЭВЛЭРҮҮЛЭН ЗУУЧЛАХ АЖИЛЛАГАА

27 дугаар зүйл. Иргэний хэрэгт эвлэрүүлэн зуучлалыг хэрэглэх

27.1.Шүүхэд иргэний хэрэг, арбитраг маргаан үүсгэснээс хойш талууд хамтарч хүсэлт гаргасан тохиолдолд эвлэрүүлэн зуучлах ажиллагааг явуулж болно.

27.2.Иргэний хэрэг үүсгэснээс хойш эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулах болсон тохиолдолд шүүх үүсгэсэн иргэний хэргийн хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлнэ.

27.3.Талууд эвлэрүүлэн зуучлах ажиллагааны үр дүнд эвлэрсэн бол шүүх Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу талуудын эвлэрлийг батлаж, хэргийг хэрэгсэхгүй болгоно.

27.4.Эвлэрүүлэн зуучлах ажиллагаа амжилтад хүрээгүй дуусгавар болсон тохиолдолд шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг сэргээж, хэргийг ердийн журмаар хянан шийдвэрлэнэ.

27.5.Нэхэмжлэлийн хэд хэдэн шаардлагад иргэний хэрэг үүсгэсэн тохиолдолд талууд бүх шаардлага, эсхүл аль нэг буюу хэд хэдэн шаардлагын талаар эвлэрүүлэн зуучлагчийн туслалцааг ашиглаж болно.

27.6.Иргэний хэрэг үүсгэснээс хойш явагдах эвлэрүүлэн зуучлах ажиллагааны хугацааг шүүх энэ хуульд зааснаас богингосон хэмжээгээр тогтоож болно.

28 дугаар зүйл.Хөдөлмөрийн эрх зүйн маргааныг эвлэрүүлэн зуучлах ажиллагаа

28.1.Хөдөлмөрийн эрх зүйн маргааныг эвлэрүүлэн зуучлах ажиллагаа нь хөдөлмөрийн хамтын маргаанаас бусад ажил олгогч болон ажилтны хооронд гарсан хөдөлмөрийн маргааны хүрээнд явагдана.

28.2.Хөдөлмөрийн эрх зүйн маргаан Хөдөлмөрийн тухай хуулийн 126.1-д заасан хөдөлмөрийн маргаан таслах комиссоор хянан шийдвэрлэсэн нь тухайн маргааныг Хөдөлмөрийн тухай хуулийн 127.1-д зааснаар шүүх хянан шийдвэрлэхэд эвлэрүүлэн зуучлах ажиллагааг ашиглах боломжид саад болохгүй.

29 дүгээр зүйл.Гэр бүлийн холбогдолтой маргааныг эвлэрүүлэн зуучлах ажиллагаа

29.1.Энэ хуулийн 5.3-т зааснаар шүүхээс гадуур урьдчилан шийдвэрлэх журмын дагуу явуулсан эвлэрүүлэн зуучлах ажиллагаа амжилтгүй болсон нь шүүхэд иргэний хэрэг үүсгэснээс хойш гэр бүлийн холбогдолтой маргааны талаар эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулахаас татгалзах үндэслэл болохгүй.

29.2.Шүүх гэрлэгчдийг эвлэрүүлэхээр Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 132.1-д заасан арга хэмжээг авахдаа эвлэрүүлэн зуучлагчийн туслалцааг авна.

29.3.Шүүх гэрлэгчидтэй ганцаарчилсан болон хамтын уулзалтыг удаа дараа хийж, зөрчил, маргааны бодит шалтгаан, үндэслэлийг тогтоох болон талуудын санал, хүсэлтийг хэрхэн шийдвэрлэх талаар харилцан ярилцана.

29.4.Гэр бүлийн маргаанд оролцогчдыг сэтгэл зүйчид хандуулж, зөвлөгөө авахуулах, садан төрөл, найз нөхөд, хамтран ажиллагсадтай уулзаж, саналыг сонсох зэргээр эвлэрүүлэх ажиллагаанд оролцуулж болно.

ДОЛДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

30 дугаар зүйл.Эвлэрүүлэн зуучлах ажиллагааг сурталчлах

30.1.Эвлэрүүлэн зуучлах ажиллагааг олон нийтэд сурталчлах, тайлбарлан таниулах, талуудыг эвлэрэхэд дэмжлэг үзүүлэх зэрэг ажлыг эвлэрүүлэн зуучлах байгууллага болон шүүхийн тамгын хэлтэс, алба болон шүүхийн мэдээлэл, лавлагааны алба хэрэгжүүлнэ.

31 дүгээр зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

31.1.Энэ хуульд заасан журмыг зөрчсөн этгээдэд шүүх дор дурдсан захиргааны хариуцлага хүлээлгэнэ:

31.1.1.энэ хуулийн 4.1.4-т заасан эвлэрүүлэн зуучлах ажиллагааны явцад ил болсон мэдээллийг талуудын зөвшөөрөлгүй бусдад задруулсан этгээдийг 100 000 – 250 000 төгрөгөөр торгох;

31.1.2.энэ хуулийн 11.2.3-т заасан эвлэрүүлэн зуучлагчийн дуудлага, товлосон уулзалтад хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүрэлцэн ирээгүй этгээдийг 50 000 – 100 000 төгрөгөөр торгох.

31.2.Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль тогтоомжийг зөрчсөнөөс учирсан хохирлыг Иргэний хуулийн дагуу нөхөн төлүүлнэ.

32 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

32.1.Энэ хуулийг 20 ... оны ... дугаар сарын ...- ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ